ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

***Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит***

**Аудитын код:** ***ДОА-2021/93/СТА-ТШЗ***


Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Аудитор: Ө.Сийлэгмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: Khaanconsultingaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |

## Агуулга


1.Хараат бус аудиторын дүгнэлт....3

2.1 Аудит хийсэн санхүүгийн тайлан....5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан....10

3. АУДИТЫН ТАЙЛАН....11

- 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ....11
- 3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ....11
- 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ....11
- 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ....11
- 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД....12
- 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ....13
- 3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ....13
- 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ....14
- 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....14
  - Залруулсан алдаа....14
  - Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил....14
- 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД....14

4. Менежментийн захидал....15

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт....16

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 149

танай ______________-ны № ______________-т

ЧУЛУУНХОРООТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Л.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **140409210.35** | **161772469.92** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0.00 | 0.00 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | 0.00 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 140409210.35 | 161772469.92 |
| **351** | **Түүхий эд материал** | 0.00 | 2948030.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 0.00 | 1908030.00 |
| 35130 | Эм боох материал | 0.00 | 1040000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 86129210.35 | 106824439.92 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 0.00 | 632900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 84847120.35 | 101610269.92 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1282090.00 | 2044250.00 |
| 35460 | Хүнсний материал | 0.00 | 2537020.00 |
| 35600 | Мал амьтад | 54280000.00 | 52000000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **826966758.63** | **1817498825.89** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 826966758.63 | 1817498825.89 |
| **392** | **Биет хөрөнгө** | 810166758.63 | 1800698825.89 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 653126073.10 | 1612605290.10 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -27831644.40 | -55663288.80 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 48000000.00 | 48000000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -31333333.49 | -39333333.53 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 119777585.20 | 153043827.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -61992163.13 | -80921424.84 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 67959263.69 | 78899398.69 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -36336092.70 | -44349844.29 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 34580000.00 | 34580000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -1565833.35 | -4273833.39 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 18000000.00 | 18000000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 17986928.70 | 79486928.70 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -204024.99 | -1020124.95 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 10000000.00 | 0.00 |
| 39217 | Ном | 0.00 | 1645231.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 16800000.00 | 16800000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16800000.00 | 16800000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **967375968.98** | **1979271295.81** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **967375968.98** | **1979271295.81** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 967375968.98 | 1979271295.81 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 367907453.88 | 367907453.88 |
| 51101 | Өмч: - төрийн | 351107453.88 | 351107453.88 |
| 51102 | - хувийн | 16800000.00 | 16800000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -38939206.78 | 972956120.05 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -38939206.78 | -38939206.78 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 1011895326.83 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 638407721.88 | 638407721.88 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **967375968.98** | **1979271295.81** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **679750597.20** | **1815602193.57** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **0.00** | **0.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **30472200.00** | **1088714734.57** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 30472200.00 | 1088714734.57 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 30472200.00 | 1088714734.57 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 30472200.00 | 1088714734.57 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **649278397.20** | **726887459.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 649176397.20 | 672749600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 37500000.00 | 0.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 65623397.20 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 546053000.00 | 672749600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 102000.00 | 15705859.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 15705859.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 102000.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 0.00 | 38432000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 0.00 | 38432000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **661114670.80** | **803706866.74** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **661114670.80** | **803706866.74** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 645516182.80 | 746841914.41 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 424960656.00 | 507518814.01 |
| 210101 | Үндсэн цалин | 319088943.00 | 366971257.01 |
| 210102 | Нэмэгдэл | 64157200.00 | 97682065.00 |
| 210104 | Урамшуулал | 41714513.00 | 42865492.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 54784400.00 | 65908684.22 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36477200.00 | 46094500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4620800.00 | 4338300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3696300.00 | 2781400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 908300.00 | 4628084.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9081800.00 | 8066400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32411494.00 | 33561137.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8492334.00 | 7698491.34 |
| 210302 | Түлш, халаалт | 23569160.00 | 25862646.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 350000.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 34745104.33 | 34118824.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 1213200.00 | 867100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2636500.00 | 1472363.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 200000.00 | 350000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 1235663.60 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 681960.00 | 503698.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 30013444.33 | 29690000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 25780412.00 | 17253209.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 126000.00 | 1436000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 25654412.00 | 15817209.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5200000.00 | 2597000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5200000.00 | 2597000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1500000.00 | 637400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1500000.00 | 637400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 588000.00 | 689016.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 588000.00 | 348000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 341016.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 65546116.47 | 84557828.74 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 102000.00 | 15705859.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4111500.00 | 2553212.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 61332616.47 | 66298757.74 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 15598488.00 | 56864952.33 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15246036.00 | 10044690.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 15246036.00 | 10044690.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 352452.00 | 46820262.33 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 352452.00 | 46820262.33 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **18635926.40** | **1011895326.83** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 12267451.80 | 0.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 12267451.80 | 0.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -12267451.80 | 0.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **6368474.60** | **1011895326.83** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **583655000.00** | **726887459.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **0.00** | **0.00** |
| **110** | **Орлогын албан татвар** | 0.00 | 0.00 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 0.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **583655000.00** | **726887459.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 583553000.00 | 672749600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 37500000.00 | 0.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 546053000.00 | 672749600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 102000.00 | 15705859.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 15705859.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 102000.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 0.00 | 38432000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 0.00 | 38432000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **583655000.00** | **726887459.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **583655000.00** | **726887459.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **568056512.00** | **669375896.67** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 424960656.00 | 507518814.01 |
| 210101 | Үндсэн цалин | 319088943.00 | 366971257.01 |
| 210102 | Нэмэгдэл | 64157200.00 | 97682065.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 41714513.00 | 42865492.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 54784400.00 | 65908684.22 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36477200.00 | 46094500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4620800.00 | 4338300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3696300.00 | 2781400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 908300.00 | 4628084.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9081800.00 | 8066400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32290974.00 | 34323297.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8492334.00 | 7698491.34 |
| 210302 | Түлш, халаалт | 23448640.00 | 26624806.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 350000.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8249660.00 | 10673756.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 1213200.00 | 1500000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 2636500.00 | 1472363.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 200000.00 | 350000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200000.00 | 150000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 1849973.60 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3999960.00 | 5351420.00 |
| **2105** | **Норматив зардал** | 29384822.00 | 24207619.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 126000.00 | 2500000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 25258822.00 | 17707619.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4000000.00 | 4000000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5200000.00 | 4097000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5200000.00 | 4097000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1500000.00 | 637400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1500000.00 | 637400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 588000.00 | 689016.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 588000.00 | 348000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 341016.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11098000.00 | 21320309.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 102000.00 | 15705859.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10996000.00 | 5614450.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15598488.00** | **57511562.33** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15246036.00 | 10691300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 15246036.00 | 10691300.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 352452.00 | 46820262.33 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 352452.00 | 46820262.33 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **0.00** | **0.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 0.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 367,907,453.88 | 638,407,721.88 | -38,939,206.78 | 967,375,968.98 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **367,907,453.88** | **638,407,721.88** | **-38,939,206.78** | **967,375,968.98** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | 0.00 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **367,907,453.88** | **638,407,721.88** | **-38,939,206.78** | **967,375,968.98** |
| D01 | **2020оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **367,907,453.88** | **638,407,721.88** | **-38,939,206.78** | **967,375,968.98** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **367,907,453.88** | **638,407,721.88** | **-38,939,206.78** | **967,375,968.98** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 1,011,895,326.83 | 1,011,895,326.83 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **367,907,453.88** | **638,407,721.88** | **972,956,120.05** | **1,979,271,295.81** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 583553000 | 583200548 | 711181600 | 664361337.67 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 583553000 | 583200548 | 711181600 | 664361337.67 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 568306400 | 567954512 | 698209700 | 653670037.67 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 425277500 | 424960656 | 542289000 | 507518814.01 |
| 210101 | Үндсэн цалин | 319163300 | 319088943 | 370775500 | 366971257.01 |
| 210102 | Нэмэгдэл | 64157200 | 64157200 | 124256700 | 97682065.00 |
| 210104 | Урамшуулал | 41957000 | 41714513 | 47256800 | 42865492.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 54784400 | 54784400 | 67786100 | 65908684.22 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36477200 | 36477200 | 46094500 | 46094500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4620800 | 4620800 | 4338300 | 4338300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3696300 | 3696300 | 1084600 | 2781400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 908300 | 908300 | 5422900 | 4628084.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9081800 | 9081800 | 10845800 | 8066400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32300000 | 32290974 | 34052000 | 34323297.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9320000 | 8492334 | 7709200 | 7698491.34 |
| 210302 | Түлш, халаалт | 22630000 | 23448640 | 26342800 | 26624806.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 350000 | 350000 | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8250200 | 8249660 | 10673900 | 10673756.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 1213200 | 1213200 | 1500000 | 1500000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2637000 | 2636500 | 1472400 | 1472363.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 200000 | 200000 | 350000 | 350000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200000 | 200000 | 150000 | 150000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0 | 0 | 1850000 | 1849973.60 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4000000 | 3999960 | 5351500 | 5351420.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 29406300 | 29384822 | 31866100 | 24207619.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 126000 | 126000 | 2500000 | 2500000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 25280300 | 25258822 | 25366100 | 17707619.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4000000 | 4000000 | 4000000 | 4000000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5200000 | 5200000 | 4380000 | 4097000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5200000 | 5200000 | 4380000 | 4097000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1500000 | 1500000 | 637400 | 637400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1500000 | 1500000 | 637400 | 637400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 588000 | 588000 | 910000 | 689016.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 588000 | 588000 | 550000 | 348000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0 | 0 | 360000 | 341016.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11000000 | 10996000 | 5615200 | 5614450.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11000000 | 10996000 | 5615200 | 5614450.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 15246600 | 15246036 | 12971900 | 10691300.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15246600 | 15246036 | 12971900 | 10691300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 15246600 | 15246036 | 12971900 | 10691300.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 583553000 | 583553000 | 711181600 | 711181600.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 583553000 | 583553000 | 711181600 | 711181600.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.0** | **0.0** | 0.00 | 0.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 48 | 48 | 48 | 48 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 29 | 29 | 29 | 29 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 18.0 | 18.0 | 18.00 | 18.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **15,705,859** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **15,705,859** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 15,705,859 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 15,705,859 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 15,705,859 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 15,705,859 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 15,705,859 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 15,705,859 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

# 3. АУДИТЫН ТАЙЛАН

## 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Л.Мөнхцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 28-ноос 2021 оны 02 дүгээр сарын 20–ний хооронд Хаан Консалтинг ХХК-ны Аудитор Ө.Сийлэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургууль 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжиж, мэдээллийн технологийг хэрэглэх чадвараа нэмэгдүүлэн, ээлжит хичээл нэг бүрийг бэлтгэл сайтай зохион байгуулж, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо хамтын ажиллагааг сайжруулж, хүүхэд бүрийн сурах хүсэл тэмүүллийг өрнүүлэн, тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлж эрүүл мэндээ хамгаалах, ариун цэврийг сахих энгийн зөв дадал хэвшилд сургана. Энэхүү зорилгыг хангах чиглэлээр 5 зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 803,706.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 16,074.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,011,895.3 мянган төгрөгөөр буюу 100 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 140,409.2 | 161,772.4 | -21,363.2 |
| Үндсэн хөрөнгө | 826,966.7 | 1,817,498.8 | -990,532.1 |
| **Нийт хөрөнгө** | **967,375.9** | **1,979,271.2** | **-1,011,895.3** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 967,375.9 | 1,979,271.2 | -1,011,895.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 967,375.9 | **1,979,271.2** | **-1011,895.3** |

Санхүүгийн тайлангаар авлагагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 161,772.4 мянган төгрөг болж 21,363.2 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хандив тусламжаар 9,273.8 мянган төгрөг, 27,410.0 мянган төгрөгийн малын нас дэвшил,төлийн орлогыг бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,816,070.8 мянган төгрөг болж 990,532.1 мянган төгрөгөөр өссөн нь улсын төвийн хөрөнгө оруулалтаар 943,773.0 мянган төгрөгийн спорт заалны барилга, аймгийн ОНХС-аар дотуур байрны цахилгааны монтаж засвар 15,705.9 мянган төгрөг, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 61,500.0 мянган төгрөгийн ариун цэврийн байгууламж, аймаг болон сум хөгжлийн сангаас сургуулийн тохижилтод 31,052.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийгдсэн байна.Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4,799.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж байна. Үндсэн хөрөнгийн тайлант хугацааны элэгдлийн зардал 66,298.7 мянган төгрөг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл байхгүй байна.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 77,609.0 мянган төгрөгөөр буюу 12 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 142,592.2 мянган төгрөгөөр буюу 21,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагадсан зэргээс шалтгаалсан байна.

## 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 683,188.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 683,188.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 27,993.4 мянган төгрөгөөр нэмэгдэж 711,181.6 мянган төгрөгөөр баталсан байна.

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 711,181.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 672,749.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 25,366.1 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 672,749.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 38,732.0 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 670,661.4 мянган төгрөгийг зарцуулж 40,820.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 648,655.5 мянган төгрөг буюу 90 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 34,869.4 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэл 1,877.4 мянган төгрөгөөр, хүнс 7,658.4 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал 2,280.6 мянган төгрөг, бусад зардал 134,4 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахалтай холбоотой хөл хорио тогтоож үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн ОНХС-аас сургуулийн дотуур байрны цахилгааны монтаж засварын санхүүжилт 15,705.8 мянган төгрөг орж гүйлгээ хийгдсэн байна.

## 3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл буюу 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээг бүрэн байршуулсан байна.

## 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 46,649.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг 100.0 хувьтай байна

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | 46,649.3 | 2 | 46,649.3 | 2 | 46.649.3 | 100 |
| | | | | | | | |
| Нийт дүн | 2 | 46,649.3 | 2 | 46,649.3 | 2 | 46.649.3 | 100 |

## 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 60,337.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 11,645.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 48,692.1 мянган төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрснээс 27,385.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 21,306.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүллээ.

### Залруулсан алдаа

Аудитаар БСУГ-аас үнэ төлбөргүй олгосон 1,645.2 мянган төгрөгийн сурах бичиг болон номыг санхүүгийн тайланд тусгаагүй, 2019 онд Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй халаалтын зуухыг капиталжуулахдаа нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтийг буруу хийж зардлаар бүртгэсэн тул санхүүгийн тайланд тус тус залруулга хийлгэв.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

1. Худалдан авалт хийсэн бараа үйлчилгээний 106,639.7 мянган төгрөгийн зардал гарснаас 79,253.9 мянган төгрөгийн зардал и-баримттай бөгөөд 27,385.7 мянган төгрөг и-баримтгүй байна. Энэ нь үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж .., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт ”Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Балансын данстай холбоотой асуудал*

1. Илрүүлэлт: Санхүүгийн тайланд ном, сурах бичгүүдийг дансны ангилал , шинж чанар, зориулалтаар бүртгээгүй Бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна

1.1 Эрсдэл: Санхүүгийн тайлангийн бүтэц, тодруулга тайлангууд тодорхойгүй, эдийн засгийн тооцоолол буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

1.2 Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг нягтлан бодох бүртгэлийн УСНББОУС-17 *Үндсэн хөрөнгө*-ийг, Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 253 дугаар тушаалын гуравдугаар хавсралт НББ-ын дансны заавар. "Номын сангийн номын фондыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байгууллага үндсэн хөрөнгийн холбогдох дансанд бүртгэнэ" гэсэн заалтыг дагаж мөрдөх.

1.3 .Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлж ажиллана

*Дотоод хяналттай холбоотой асуудал*

2. Тайлант хугацааны сар бүрийн эхэнд байгууллагын удирдлага хувийн өргөдлөөр жилийн турш 7,400.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгосон байна.

2.1 Эрсдэл: Сарын батлагдсан төсвийн хуваарийн дагуу зарцуулахгүй байх, санхүүгийн сахилга бат зөрчигдөх, хөрөнгө шамшигдах эрсдэлтэй.

2.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах , байгууллагын дотоод журам заалтуудыг мөрдөж ажиллах.

2.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: **2020**

Аудитын нэр: ***Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит***

Аудитын код: ДОА-2021/93/СТА-ТШ3

Шалгагдсан байгууллагын нэр: Чулуунхороот сумын Ерөнхий боловсролын сургууль

Мянган төгрөгөөр

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ном, сурах бичигийг Бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна. | 13,906.4 | Зөвлөмж | Захирал, нягтлан бодогч | Л.Мөнхцэцэг И.Оюунтунгалаг |
| 2 | Худалдан авалт хийсэн бараа үйлчилгээний 106,639.7 мянган төгрөгийн зардал гарснаас 79,253.9 мянган төгрөгийн зардал и-баримттай бөгөөд 27,385.7 мянган төгрөг и-баримтгүй байна. | 27,385.7 | Албан шаардлага өгөх | Захирал, нягтлан бодогч | Л.Мөнхцэцэг И.Оюунтунгалаг |
| 3 | Сар бүрийн эхэнд тогтмол хэдэн хүн хувийн хэрэгцээнд гэсэн өргөдөл бичээд 12 сарын турш 7,400.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа авсан байна. | 7,400.0 | Зөвлөмж хүргүүлэх | Захирал, нягтлан бодогч | Л.Мөнхцэцэг И.Оюунтунгалаг |
| 4 | БСУГ-аас үнэ төлбөргүй олгосон 1,645.2 мянган төгрөгийн сурах бичиг болон номыг санхүүгийн тайланд тусгаагүй | 1645,2 | Санхүүгийн тайланд залруулга | Захирал, нягтлан бодогч | Л.Мөнхцэцэг И.Оюунтунгалаг |
| 5 | 2019 онд Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй халаалтын зуухыг капиталжуулахдаа зардлаар бүртгэснээр үр дүнгийн тайлан алдаатай илэрхийлэгдсэн байна. | 10,000.0 | Санхүүгийн тайланд залруулга | Захирал, нягтлан бодогч | Л.Мөнхцэцэг И.Оюунтунгалаг |
| **ДҮН** | | **60,337.3** | | | |